

# НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТҮГ-ЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧИГЛЭЛЭЭР 2022 ОНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2022 оны 12 дугаар сарын 10

Налайх дүүрэг

## **Нэг. Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр**

Байгууллагын хүний нөөцийн бодлогын баримт бичгийн хүрээнд шаардлагатай төлөвлөгөөнүүдийг боловсруулсан. Үүнд:

- Ажилчдын нийгмийн баталгааг хангах төлөвлөгөө
- Сургалт, хөгжлийн төлөвлөгөө
- Спорт хамтлагийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.

Хөдөлмөрийн хууль шинэчлэгдсэнтэй холбогдуулан байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмыг Даргын 2022 оны А/01 дүгээр тушаалаар шинэчлэн баталж, Хөдөлмөрийн гэрээг нийт албан хаагчидтай байгуулсан.

Шинэчлэгдсэн Хөдөлмөрийн дотоод журмын 5.2.16-т Албан үүргээ гүйцэтгэхдээ хэнийг ч ялгаварлаж хандахгүй байхын зэрэгцээ хамт ажиллаж байгаа болон бусад хүмүүсийн нэр төр, ажил хэргийн нэр хүндэд хүндэтгэлтэй хандах, 5.2.9-т Ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг таслан зогсоох, хөдөлмөрийн гэрээний 2.2.7, 2.3.5-т жөндөрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байх, эрх тэгш байдлыг хангаж ажиллах талаар ажил олгогч, ажилтны эрх, үүргийг заасан.

“Нандин бүхнээ хамгаалья-Өөрийгөө, гэр бүлээ, орчин тойрноо” уриан дор зохион зохион байгуулсан Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх аянд оролцсон.

Нийслэл дэх Жендерийн салбар хороо – “Жендэр ба хүний эрх” сургалтад байгууллагын удирдлага хамрагдсан.

Шинэчлэгдсэн Хөдөлмөрийн дотоод журмын 5.2.3, 5.2.4, хөдөлмөрийн гэрээний 2.2.2, 2.3.2, 2.4.3-т хөдөлмөрийн аюулгүй орчин, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн нөхцөлөөр хангах, хангуулах, аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдөж ажиллахыг заасан.

2020 оны даргын А/28 дугаар тушаалаар “Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны бодлого, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм”, А/29 дүгээр тушаалаар “Хөдөлмөрийн аюулгүй байла, эрүүл ахуйн зааварчилгаа” – г баталсан ба төлөвлөгөө гарган ажиллаж байна.

## **Хоёр. Хүний нөөцийн сургалт, хөгжлийн чиглэлээр**

Байгууллагын албан хаагчдаас сургалтын хэрэгцээг тодорхойлох асуулга авч, Хүний нөөцийн сургалт, хөгжлийн төлөвлөгөө гарган ажилласан. Холбогдох газруудаас зохион байгуулсан 17 сургалтад давхардсан тоогоор 37 албан хаагчийг танхим болон цахимаар хамруулсан. Үүнд:

- НД-ийн Татварын хэлтэс-Хөрөнгө орлогын мэдүүлэг – 12 албан хаагч
- НЗДТГ- Нийслэл RISE-Academy сургалт – 1
- НД-ийн Цэцэрлэгжүүлэлтийн алба – Агротехникийн мэдлэг олгох сургалт – 2

- НБИХГ-Төр хувийн хэвшлийн түншлэл сургалт, хэлэлцүүлэг – 5
- НАГ- Албан хэрэг хөтлөлтийн шинэчлэгдсэн журмыг танилцуулах сургалт – 1
- НАГ- Төрийн архивт нөхөн бүрдүүлэлт хийх байгууллагуудад чиглэл олгох сургалт – 1
- НӨХГ –Төрийн өмчийн тооллогын системийн сургалт – 2
- НЗДТГ- Нийслэл 110 Менторшип хөтөлбөр – 1
- НЗДТГ-ын Хууль зүйн хэлтэс-Хөдөлмөрийн хуулийн шинэчилсэн найруулгын тухай – 2
- НАГ-Шинээр томилогдсон албан хаагчдад архив, албан хэрэг хөтлөлтийн мэдлэг олгох сургалт – 2
- НЗДТГ, “Легал линк си би эй”-FIDIC-ийн жишиг гэрээ, түүний онцлог сургалт – 1
- НЗДТГ, Удирдлагын академи–Төрийн байгууллагын ёс зүйн зөвлөлийг чадавхжуулах нь сургалт – 1
- НЗДТГ-ын Хөгжүлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс-"Улс, нийслэлийн урт, дунд хугацааны бодлоготой уялдуулан Нийслэлийн богино хугацааны төлөвлөлтийн бичиг баримт боловсруулах нь" сэдэвт сургалт -1
- Нийслэл дэх Жендерийн салбар хороо – “Жендэр ба хүний эрх” сургалт – 1
- НЗДТГ – “Захиргааны байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээний чадавхыг бэхжүүлэх” сургалт – 2
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Хэлний бодлогын үндэсний зөвлөл, Архивын ерөнхий газар - Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III-ыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд боловсруулсан эрх зүйн баримт бичиг, шинэчилсэн стандартыг танилцуулах, Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтнуудад мэдээлэл өгөх, хэвлэмэл хуудас ашиглах заавар, зөвлөгөө – 1
- НЗДТГ – “HR-2022” чуулга – 1



Дотоод сургалтыг 3 удаа зохион байгуулсан. Үүнд:

- Албан бичиг, тайлан, төлөвлөгөө, түүний биелэлт гаргах
- Эдокийн боловсруулалт цэсээр албан бичиг боловсруулах талаар зохион байгуулж давхардсан тоогоор 14 албан хаагч оролцсон.

Ажилтнуудад хууль, эрхзүйн мэдлэг олгох үүднээс "Хуулийн цаг" мэдээллийн цагийг зохион байгуулж дараах чиглэлээр 4 удаа мэдээллийг өгсөн. Үүнд:

- Шилэн дансны тухай хууль
- Үйлдвэр технологийн эрх зүйн байдлын тухай хууль шинэчлэгдсэнтэй холбогдуулан өөрчлөлт орсон зүйл заалтын талаар,
- Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III-ыг хэрэгжүүлэх зорилго зорилтыг паркт хэрхэн уялдуулах талаар,

Төсвийн хэмнэлтийн хуулийн мэдвэл зохих зүйл заалтуудын талаар тус тус мэдээлэл хийж давхардсан тоогоор 34 албан хаагч хамрагдсан. Дээрх сургалтуудад нийт 107 албан хаагч хамрагдсан. /сургалтын зургийг тоймлон оруулав/





“V world korea” ХХК-ийн урилгаар Бүгд Найрамдах Солонгос Улсад НБМҮТП-ийн удирдлага болон инженерүүд дэлхийн улс орнуудад жишиг болсон БНСУ-ын томоохон үйлдвэрлэгч байгуулагуудын үйлдвэрлэл, шинэ дэвшилтэт техник технологитой танилцах, туршлага судлах, үйлдвэрлэлийн процессыг газар дээр нь үзэх, паркад нутагшуулж болохуйц үйлдвэрлэлийг татан оруулж ирэх, гэрээ байгуулсан БНСУ-ын хөрөнгө оруулалт бүхий компанийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцах зорилго бүхий айлчлалыг зохион байгууллаа.



## Гурав. Хүний нөөцийн нийгмийн баталгааг хангах чиглэлээр

Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд хууль, дүрэмд нийцүүлэн дараах дэмжлэг, туслалцааг олгосон. Үүнд:

- Хөдөлмөрийн дотоод журмын 8.3.3-т заасны дагуу хүүхэд асрах чөлөөтэй 3 албан хаагчид тус бүр 165,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Төрийн хэмнэлтийн хуультай холбогдуулан төсөв хүрэлцээгүйн улмаас журамд заасан мөнгөн дүнд хүрээгүй болно.
- Тухайн онд ажлын үр бүтээлтэй, хамт олноо манлайлан, зөрчилгүй ажилласанг үнэлэн 2 албан хаагчийг нэг сарын цалингаар шагнаж урамшуулсан.

Ажлын үр дүнгээс хамааран хагас жилийн үр дүнгийн урамшуулал, сарын ур чадварын нэмэгдэл олгож байна.

Албан хаагчдын ээлжийн амралтын саналын дагуу ээлжийн амралтын хуваарь гарган батлуулж, хуваарийн дагуу ээлжийн амралтыг биеэр эдэлсэн. Албан хаагчдад шаардлагатай чөлөөг тухай бүр нь олгосон.

2022 оны төсөвт ажилтан, албан хаагчдыг урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулах төсөв тусгагдаагүй тул албан хаагчдыг НД-ийн хөнгөлөлтөөр эрт элрүүлэг шинжилгээнд хамрагдах нөхцөл бололцоогоор ханган ажиллаж байна. Одоогийн байдлаар 2 албан хаагч бүрэн хамрагдаж, шинжилгээний үр дүнгийн дагуу эмчилгээ хийлгэж байна.

5 албан хаагчийн салбар болон төрийн дээд шагналд өргөн мэдүүлсэн шагналын анкетийг холбогдох газруудад хүргүүлж үүнээс:

- Монгол улсын төрийн дээд шагнал Хөдөлмөрийн хүндэт медаль – 1
- БХБЯ-ны Тэргүүний барилгачин – 1 тус тус шагналаар шагнаж урамшуулсан.



Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр, хүүхдийн баярыг тохиолдуулан байгууллагын 15 ажилтан, албан хаагчдын 0-16 насны нийт 31 хүүхдэд бяцхан гарын бэлэг гардуулсан.



Спорт хамтлагийн ажлын төлөвлөгөө боловсруулан Зуны аялалыг Сэлэнгэ аймаг руу аялахаар төлөвлөн зохион байгуулж, 9 албан хаагч хамрагдсан.

“50 кофейн уналт” асуулт хариултын тэмцээнийг зохион байгуулсан.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн санаачилсан “Алхацгаая, гүйцгээе” хөдөлгөөний хүрээнд албан хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, түүх, дурсгалт газруудтай танилцах зорилтын дор зохион байгуулж Налайх-Төв аймаг Манзуширын хийд-Цэцээ гүний оргил-Налайх маршрутаар явган алхалтыг удирдамжын дагуу явуулсан.

4 улиралд зохион байгуулах тэмцээнийг спорт хамтлагийн төлөвлөгөөний дагуу явуулах бэлтгэл байдлыг хангаж байна.

### ***Дөрөв. Хүний нөөцийн ил тод байдлыг хангах чиглэлээр***

Байгууллагад шаардлагатай сул ажлын байрны зарыг байгууллагын вебсайт, тухайн ажлын байртай холбогдох цахим сайт, фэйж хуудас болон Налайх дүүргийн Хөдөлмөр, халамжийн хэлтэст мэдээллэсэн.

Байгууллагын ажилчидтай холбоотой тусламж, дэмжлэг олгох тушаалыг байгууллагын вебсайт болон шилэн дансны мэдээлэлд тухай бүр нь оруулж байна.

### ***Тав. Хүний нөөцийн мэдээлэл судалгааны чиглэлээр***

Тус онд өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн – 2, шинээр ажилд орсон – 2, жирэмсний болон амаржсаны амралт, хүүхэд асрах чөлөөтэй – 3 албан хаагчийн мэдээллийг UB-ERP албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн удирдлагын системийн Хүний нөөцийн модулийн мэдээлэлд тухай бүр нь шинэчлэн оруулсан.

Хүний нөөцийн шаардлагатай мэдээ, судалгааг олбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

### ***Зургаа. Нийслэл, дүүргээс зохион байгуулсан үйл ажиллагааны чиглэлээр***

“Их хотоо эзний сэтгэлээр цэвэрлэе” уриан дор зохион байгуулах бүх нийтийн хаврын их цэвэрлэгээний ажилд байгууллагын хуваарьт газрыг цэвэрлэсэн.



Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх, иргэдэд мод тарих соёлыг сурталчилан түгээх ажлын хүрээнд “Шинэ-Налайх” цэцэрлэгт хүрээлэнд “Ногоон хот-Иргэний оролцоо” мод тарих арга хэмжээний нээлтэд оролцож, хөл Налайхт өмнөх онд тарьсан мод сөөгний арчилгаа, тордолтыг хийсэн.



Налайхын их уурхай, дүүргийн 100 жилийн ой, "Үндэсний бичиг үсгийн баяр"-ыг тохиолдуулан Налайх дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын нэрэмжит уламжлалт "Үндэсний бичиг мину" уралдаан дүүргийн 56 албан байгууллагын 112 ажилтан, албан хаагчдын дунд зохион байгуулагдсан. Тус тэмцээнд Паркийг төлөөлж 2 албан хаагч оролцоноос Паркийн Хөрөнгө оруулалтын мэргэжилтэн Т.Тэлмэн тусгай байр эзлэсэн байна.



"Тэрбум мод" хөтөлбөрийн хүрээнд хуваарийн дагуу Налайхын зүүн чиглэлийн автозамын А/24 постноос Хөнгөн блокны үйлдвэр хүртэл зам дагуу 130 ширхэг хайлаас, 10 ширхэг улиас модны суулгацыг тарьж усалгаа арчилгааг хийн цэцэрлэгжүүлэлтийн албанд хүлээлгэн өгсөн.





Налайх дүүргийн Засаг даргын тамгын газраас зохион байгуулсан Үндэсний их баяр наадмын нээлтийн ажиллагаанд оролцсон



ХЯНАСАН:  
ДАРГА

С.БАТЖАРГАЛ

2022 оны ..... дугаар сарын ..... –ны өдөр

ТАЙЛАН ГАРГАСАН:  
ЗАХИРГААНЫ АЖИЛТАН

Д.НОМИН-ЭРДЭНЭ